



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/15/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Нямтөмөр
Утас: 261740 Цахим хаяг: nyamtumurl@audit.gov.mn
Аудитор: С.Бат-Эрдэнэ
Утас: 261740 Цахим хаяг: bat-erdenes@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	13
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	13
3.5.2 Авлага	14
3.5.3 Урьдчилгаа	14
3.5.4 Бараа материал	15
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	15
3.5.5 Үндсэн хөрөнгө	15
3.5.6 Өр төлбөр	16
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	19
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	20
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	21
4.1 Харьяа байгууллагууд.....	21
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч.....	21
4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа	21
4.2.2 Албан шаардлага	21
4.2.3.Зөвлөмж.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23
5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД
ТАНАА

2022.03.25 № 01/712
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,708,968.1	70,784,443.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,767,642.4	2,407,422.5
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
33	АВЛАГА	404,953.8	347,250.4
34	УРЬДЧИЛГАА	3,720,436.4	16,393,664.4
35	БАРАА МАТЕРИАЛ	46,623,731.5	48,921,707.5
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	0.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	3,192,204.0	2,714,399.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	226,279,310.4	231,858,796.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	226,279,310.4	231,858,796.5
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	208,849,664.2	213,734,776.3
39300	Биет бус хөрөнгө	17,429,646.2	18,124,020.2
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	288,988,278.4	302,643,240.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,169,157.5	6,181,536.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,169,157.5	6,181,536.1
41300	Өглөг	2,301,240.3	4,465,850.4
41400	Урьдчилж орсон орлого	8,867,917.3	1,715,685.7
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
42100	Урт хугацаат үнэт цаас	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	277,819,120.9	296,461,704.3
51	Засгийн газрын хувь оролцоо	277,819,120.9	296,461,704.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	83,315,093.6	84,065,917.3
51200	Хуримтлагдсан үр дүн	137,615,398.9	155,901,589.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,888,628.4	56,494,197.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	288,988,278.4	302,643,240.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	279,857,725.3	293,398,101.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,965,992.9	25,592,477.0
120	Нийтлэг татварын бус орлого	24,660,163.0	25,222,909.8
121	Хөрөнгийн орлого	0.0	0.0
122	Тусламжийн орлого	305,829.9	369,567.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0
124	Зээлийн орлого	0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	254,891,732.4	267,805,624.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	251,550,754.6	274,462,519.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	251,550,754.6	274,462,519.7

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	228,251,286.9	250,966,051.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	155,299,326.7	170,732,363.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,864,523.5	4,119,325.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,221,378.7	5,561,844.6
2104	Хангамж, бараа материалын зардал	10,473,260.8	12,946,824.0
2105	Норматив зардал	11,753,421.0	11,005,019.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,269,905.7	4,691,143.5
2107	Томилолт, зочны зардал	612,677.1	551,868.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,433,784.8	15,288,080.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,323,008.5	26,069,582.1
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,299,467.7	23,496,468.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	28,306,970.7	18,935,581.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	5.9	730.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,065,115.8	1,174,502.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	27,241,860.8	17,761,809.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,881,541.4	0.0	249,881,541.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	413,400.5	0.0	413,400.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	250,294,942.0	0.0	250,294,942.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(377,889.7)	0.0	(377,889.7)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	668,717.8	0.0	668,717.8
8	Зарласан ногдол ашиг	(8,510.0)	0.0	(8,510.0)
9	Тайлант үеийн үр дүн	27,241,860.8	0.0	27,241,860.8
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,819,120.9	0.0	277,819,120.9
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	524,381.2	0.0	524,381.2
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	278,343,502.1	0.0	278,343,502.1
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(394,431.0)	0.0	(394,431.0)
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	750,823.7	0.0	750,823.7
15	Тайлант үеийн үр дүн	17,761,809.5	0.0	17,761,809.5
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	296,461,704.3	0.0	296,461,704.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	270,299,019.2	282,746,172.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,115,076.5	14,823,427.0
120	Нийтлэг татварын бус орлого	15,115,076.5	14,823,427.0
121	Хөрөнгийн орлого	0.0	0.0
122	Тусламжийн орлого	0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	255,183,942.7	267,922,745.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	252,071,931.3	274,053,663.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	252,071,931.3	274,053,663.7
210	БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	217,415,695.5	250,480,233.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	154,271,457.6	169,773,815.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,989,400.3	4,088,810.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,241,864.4	5,605,668.8
2104	Хангамж, бараа материалын зардал	10,137,888.2	9,890,189.4
2105	Норматив зардал	12,958,600.9	13,510,852.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,433,356.8	7,808,195.3
2107	Томилолт, зочны зардал	668,995.3	612,592.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,481,380.8	29,152,805.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,232,751.2	10,037,305.3
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,656,235.8	23,573,429.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	18,227,087.9	8,692,508.3
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	18,500,668.9	15,032,360.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,500,668.9	15,032,360.6
2200	Дотоод эх үүсвэрээр	18,500,668.9	15,032,360.6
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(18,500,668.9)	(15,032,360.6)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(8,504.1)	(20,367.6)
14	Бусад эх үүсвэр	97,358.4	21,900.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	105,862.5	42,267.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(282,085.1)	(6,360,219.9)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,049,727.5	8,767,642.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,767,642.4	2,407,422.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	262,513,145,000.00	262,116,303,525.82	396,841,474.2	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	254,113,845,000.00	253,879,771,312.82	234,073,687.2	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	235,775,526,200.00	235,583,763,299.82	191,762,900.2	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,479,775,000.00	164,463,899,980.43	15,875,019.6	100.0
210101	Үндсэн цалин	87,133,305,100.00	87,230,751,223.44	(97,446,123.4)	100.1
210102	Нэмэгдэл	71,896,173,000.00	72,225,860,382.46	(329,687,382.5)	100.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	135,508,000.00	177,269,184.00	(41,761,184.0)	130.8
210105	Гэрээт ажлын хөлс	5,314,788,900.00	4,830,019,190.53	484,769,709.5	90.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,717,936,000.00	3,692,681,297.64	25,254,702.4	99.3
210201	Тэтгэврийн даатгал	22,031,300.00	34,239,623.00	(12,208,323.0)	155.4
210202	Тэтгэмжийн даатгал	8,041,000.00	6,924,284.00	1,116,716.0	86.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,433,800.00	5,540,387.00	893,413.0	86.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,607,600.00	1,383,897.00	223,703.0	86.1
210205	Эрүүл мэндийн даатгал	3,679,822,300.00	3,644,593,106.64	35,229,193.4	99.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,630,158,400.00	5,598,430,504.54	31,727,895.5	99.4
210301	Гэрэл, цахилгаан	2,046,486,400.00	2,045,174,015.17	1,312,384.8	99.9
210302	Түлш, халаалт	3,031,084,200.00	3,009,205,648.26	21,878,551.7	99.3
210303	Цэвэр, бохир ус	457,645,200.00	446,468,941.11	11,176,258.9	97.6
210304	Байрны түрээс	94,942,600.00	97,581,900.00	(2,639,300.0)	102.8
2104	Хангамж, бараа материалын зардал	9,113,567,200.00	9,101,305,175.46	12,262,024.5	99.9
210401	Бичиг хэрэг	1,181,603,000.00	1,178,902,086.54	2,700,913.5	99.8
210402	Тээвэр, шатахуун	6,470,584,800.00	6,467,811,641.66	2,773,158.3	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	850,825,500.00	847,775,841.26	3,049,658.7	99.6
210404	Ном, хэвлэл	40,595,100.00	38,499,210.00	2,095,890.0	94.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	45,561,500.00	42,969,460.00	2,592,040.0	94.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	524,397,300.00	525,346,936.00	(949,636.0)	100.2
2105	Норматив зардал	12,681,065,600.00	12,678,612,160.50	2,453,439.5	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	78,143,500.00	77,850,709.00	292,791.0	99.6
210502	Хоол, хүнс	2,757,930,100.00	2,756,141,229.50	1,788,870.5	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,844,992,000.00	9,844,620,222.00	371,778.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,067,940,300.00	7,045,259,138.09	22,681,161.9	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,880,920,700.00	2,878,417,660.00	2,503,040.0	99.9
210602	Тавилга	35,495,000.00	35,138,650.00	356,350.0	99.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	826,440,500.00	824,756,769.00	1,683,731.0	99.8
210604	Урсгал засвар	3,325,084,100.00	3,306,946,059.09	18,138,040.9	99.5
2107	Томилолт, зочны зардал	605,663,300.00	587,129,131.00	18,534,169.0	96.9
210701	Гадаад албан томилолт	45,000,000.00	44,272,790.00	727,210.0	98.4
210702	Дотоод албан томилолт	483,663,300.00	466,048,700.00	17,614,600.0	96.4
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	77,000,000.00	76,807,641.00	192,359.0	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,507,434,300.00	31,448,846,639.84	58,587,660.2	99.8

Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,531,759,800.00	27,477,856,616.94	53,903,183.1	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,430,000.00	2,706,400.00	723,600.0	78.9
210803	Даатгалын үйлчилгээ	368,410,600.00	368,410,010.40	589.6	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,491,500.00	115,995,940.50	2,495,559.5	97.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25,507,100.00	24,785,600.00	721,500.0	97.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	445,374,100.00	445,368,100.00	6,000.0	100.0
210807	Газрын төлбөр	75,680,800.00	74,943,972.00	736,828.0	99.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,938,780,400.00	2,938,780,000.00	400.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	971,986,100.00	967,599,272.32	4,386,827.7	99.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	651,498,900.00	647,651,596.32	3,847,303.7	99.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	320,487,200.00	319,947,676.00	539,524.0	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,338,318,800.00	18,296,008,013.00	42,310,787.0	99.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	74,027,100.00	73,635,516.00	391,584.0	99.5
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	74,027,100.00	73,635,516.00	391,584.0	99.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,264,291,700.00	18,222,372,497.00	41,919,203.0	99.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	78,225,600.00	74,540,150.00	3,685,450.0	95.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	799,808,400.00	799,808,400.00	0.0	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,285,907,600.00	14,265,620,519.00	20,287,081.0	99.9
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,523,053,700.00	2,523,053,700.00	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	577,296,400.00	559,349,728.00	17,946,672.0	96.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,399,300,000.00	8,236,532,213.00	162,767,787.0	98.1
220001	Барилга байгууламж	6,087,300,000.00	6,040,915,291.00	46,384,709.0	99.2
221001	Их засвар	2,000,000,000.00	1,883,800,112.00	116,199,888.0	94.2
222001	Тоног төхөөрөмж	312,000,000.00	311,816,810.00	183,190.0	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	262,513,145,000.00	262,163,208,143.38	349,936,856.6	99.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	251,242,850,300.00	250,045,490,829.34	1,197,359,470.7	99.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	251,242,850,300.00	250,045,490,829.34	1,197,359,470.7	99.5
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	252,495,000.00	269,500,000.00	(17,005,000.0)	106.7
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	252,495,000.00	269,500,000.00	(17,005,000.0)	106.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,017,799,700.00	11,848,217,314.04	(830,417,614.0)	107.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,017,799,700.00	11,848,217,314.04	(830,417,614.0)	107.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	350,000.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	350,000.00		

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	61	61	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	61	61	0.0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	11,046	11,012	34	99.7
620001	Удирдах ажилтан	181	180	1	99.4
620002	Гүйцэтгэх ажилтан	9,796	9,763	33	99.7
620003	Үйлчлэх ажилтан	448	448	0	100.0
620004	Гэрээт ажилтан	621	621	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		15,573,162,449.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ		14,968,315,690.96
210	БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		12,638,424,191.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		5,515,816,943.88
210101	Үндсэн цалин		2,661,853,113.28
210102	Нэмэгдэл		218,519,055.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		0.00
210104	Урамшуулал		1,871,569,313.60
210105	Гэрээт ажлын хөлс		763,875,462.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		405,102,682.57
210201	Тэтгэврийн даатгал		63,869,325.30
210202	Тэтгэмжийн даатгал		2,179,025.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,884,671.00
210204	Ажилгүйдлийн даатгал		424,791.00
210205	Эрүүл мэндийн даатгал		336,744,870.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		75,879,450.00
210301	Гэрэл, цахилгаан		16,246,629.00
210302	Түлш, халаалт		46,933,600.00
210303	Цэвэр, бохир ус		12,699,221.00
210304	Байрны түрээс		0.00
2104	Хангамж, бараа материалын зардал		802,302,774.00
210401	Бичиг хэрэг		69,112,190.00
210402	Тээвэр, шатахуун		500,264,806.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		108,594,074.00
210404	Ном, хэвлэл		37,650,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		86,681,704.00
2105	Норматив зардал		834,901,492.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		8,915,500.00
210502	Хоол, хүнс		744,606,692.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		81,379,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,288,404,518.06
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,454,180,528.00
210602	Тавилга		102,584,087.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		417,334,800.00
210604	Урсгал засвар		314,305,103.06
2107	Томилолт, зочны зардал		42,289,000.00
210701	Гадаад албан томилолт		0.00
210702	Дотоод албан томилолт		42,289,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,353,362,158.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,353,362,158.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,320,365,172.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,149,515,372.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		170,849,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,329,891,499.95
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,819,368,528.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		1,239,930,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		579,438,228.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		510,522,971.95
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		510,522,971.95
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		604,846,758.70
2200	Дотоод эх үүсвэрээр		604,846,758.70
220001	Барилга байгууламж		42,774,654.00
222001	Тоног төхөөрөмж		173,400,104.70
223001	Бусад хөрөнгө		388,672,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		15,573,162,449.66
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		15,573,162,449.66
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		142,533,416.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		794,606,386.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,092,243,160.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		12,543,779,487.66
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх, харьяа байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаа болон Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хооронд ахлах аудитор Л.Нямтөмөр, аудитор С.Бат-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/51 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагдаагийн ерөнхий газар нь “Ажил үйлчилгээ нь нийгмийн хөгжлийн эрэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн амар тайван амьдралын баталгааг хангасан тэргүүлэх байгууллага болох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл, зорилтоо тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
- Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх;
- Үндсэн чиг үүргийн хүрээнд урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх;
- Цагдаагийн байгууллага, албан хаагчийн эрх зүйн орчныг шинэчилж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх;
- Албан хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллах зорилт дэвшүүлэн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс нь 2021 онд харьяа байгууллага, хэлтсүүдийн үйл ажиллагаанд 11 чиглэлээр дотоод аудитыг төлөвлөн гүйцэтгэж, 63 зөвлөмж өгсөн байна. Үүнээс санхүү, нягтлан бодох бүртгэл, Шилэн дансны тухай хуулийн

хэрэгжилтийн чиглэлээр 4 дотоод аудитыг гүйцэтгэж, 22 зөвлөмж өгч, нийт хэрэгжилтийг 100 хувийн биелэлттэй гэж үнэлж тайлагнасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 251,550.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,515.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,655.0 сая төгрөгөөр буюу 4.7 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,407.4 сая төгрөг болж, өмнөх оноос 6,360.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	986.4	350.0	(636.4)
Банканд байгаа бэлэн мөнгө	8,766,656.0	2,407,072.5	(6,359,583.5)
Төрийн сангийн харилцах	8,756,413.0	2,407,053.0	(6,349,360.0)
Арилжааны банк дахь харилцах	10,096.6	19.5	(10,077.2)
Арилжааны банк дахь харилцах/ Гадаад валют/	146.3	-	(146.3)
Дүн	8,767,642.4	2,407,422.5	(6,360,219.9)

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 0.4 сая төгрөг нь касст, 2,407.1 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд байршиж байна. Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэлд хөрөнгө оруулалтын барьцааны 705.3 сая, барьцаа дэнчингийн 981.8 сая, ахмадын сангийн 720.0 сая төгрөг тус тус байна.

Аудитын илрүүлэлт:

И-баримтаар баталгаажуулаагүй бараа, ажил, үйлчилгээний 170.9 сая төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. /Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар 8.9 сая, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Цагдаагийн хэсэг 13.6 сая, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Цагдаагийн хэсэг 7.5 сая, Нийслэлийн цагдаагийн удирдах газар 82.0, Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газар 7.8 сая, Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар 7.0 сая, Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газар 25.7 сая, Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газар 9.5 сая, Налайх дүүрэг дэх Цагдаагийн газар 4.4 сая, Орхон аймаг дахь Цагдаагийн газар 4.5 сая/

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 347.2 сая төгрөг болж, өмнөх оноос 57.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	3,722.3	3,994.4	272.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	121,305.4	44,027.6	(77,277.8)
Татаас, санхүүжилтийн авлага	49,472.0	13,991.7	(35,480.3)
Дансны авлага /ТӨҮГ/	121,396.2	80,634.2	(40,762.0)
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	1,406.8	-	(1,406.8)
Байгууллагаас авах авлага	15,411.4	127,356.1	111,944.7
Хувь хүмүүсээс авах авлага	92,239.8	77,246.5	(14,993.3)
Дүн	404,953.9	347,250.5	(57,703.4)

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд татан буулгах шийдвэр гарсан Монгол тамга ТӨҮГ-ын 80,634.1 сая төгрөгийн олон жилийн насжилттай авлага бүртгэлтэй байна.

Байгууллагаас авах авлагын үлдэгдэлд Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Эрдэнэс Монгол ХХК-аас авах гэрээт алба хаагчдын 12 дугаар сарын санхүүжилтийн 96.0 сая, Сүүж-Уул сэргээн засах сувилал 810 дугаар тусгай салбарын Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлага 16.5 сая, Санхүү, аж ахуйн албаны Хангалт, үйлчилгээний төвийн 1996-2009 онуудад үүссэн 2 аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой 4.9 сая, гэрэл, цахилгааны илүү төлөлтөөс үүссэн 0.6 сая, ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны 2 аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой 9.3 сая төгрөгийн авлага бүртгэсэн байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 16,393.7 сая төгрөг болж, өмнөх оноос 12,673.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	1,617,024.9	3,110,881.3	1,493,856.4
Урьдчилгаа тооцоо	2,103,411.5	13,282,783.2	11,179,371.6
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,185,234.9	4,145,740.9	2,960,506.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	918,176.7	9,136,356.7	8,218,180.1
Цалингийн урьдчилгаа	-	685.5	685.5
Дүн	3,720,436.4	16,393,664.4	12,673,228.0

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансанд цагдаагийн алба хаагчдын 18 сарын тэтгэмжийн урьдчилгаа 666.5 сая, бусад урсгал зардлын 2,444.4 сая төгрөгийн урьдчилгаа бүртгэлтэй байна.

Бараа материал бэлтгэх урьдчилгаа дансанд цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын дүрэмт хувцас, дагалдах хэрэгсэл худалдан авах гэрээний 2,791.3 сая, холбооны хэрэгсэл худалдан авах 1,160.8 сая, бусад зардалтай холбоотой 193.9 сая төгрөгийг тус тус бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа дансанд барилгын их засварын 979.0 сая, тоног төхөөрөмж худалдан авах 14.9 сая, санхүүгийн түрээсийн гэрээний төлбөр 8,142.4 сая төгрөгийг бүртгэсэн байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 48,921.7 сая төгрөг болж, өмнөх оноос 2,298.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	14,208,510.7	13,748,249.2	(460,261.5)
Тусгай зориулалттай материал	14,021,255.4	13,495,260.2	(525,995.2)
Эм боох материал	187,255.3	252,989.0	65,733.7
Бэлэн бүтээгдэхүүн	6,301,917.4	6,282,048.4	(19,869.0)
Хангамжийн материал	25,277,382.9	27,994,319.7	2,716,936.8
Бичиг хэргийн материал	3,421,684.2	4,507,121.8	1,085,437.5
Аж ахуйн материал	1,898,267.4	2,251,402.6	353,135.2
Сэлбэг хэрэгсэл	226,616.8	230,209.6	3,592.8
Түлш, шатах тослох материал	1,682,239.4	1,656,885.2	(25,354.1)
Барилгын засварын материал	248,312.8	490,348.8	242,035.9
Хүнсний материал	187,485.0	372,081.0	184,595.9
Бусад хангамжийн материал	17,612,777.3	18,486,270.8	873,493.6
Мал амьтад	835,920.4	897,090.1	61,169.6
Дүн	46,623,731.5	48,921,707.5	2,297,976.0

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдлийн өсөлтөд бичиг хэргийн материал 1,085.4 сая, барилгын засварын материал 242.0 сая, бусад хангамжийн материал 873.5 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Бараа материал худалдаж авсан 37,444.0 сая, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 18,258.0 сая, үндсэн хөрөнгөөс бараа материал данс руу шилжүүлэн бүртгэсэн 1.4 сая, бараа материалын данс хооронд шилжүүлж бүртгэсэн 9.0 сая, бусад 683.7 сая, малын нас дэвшилтийн орлогоор 378.9 сая, нийт 56,775.0 сая төгрөгөөр нэмэгджээ.

Тайлант онд үйл ажиллагаанд 28,269.2 сая төгрөгийн бараа материал зарцуулж, системийн байгууллага хооронд шилжүүлсэн 23,385.1 сая, бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн 53.3 сая, бараа материалын данс хооронд шилжүүлэн бүртгэсэн 9.0 сая, малын нас дэвшилтийн хөдөлгөөний 378.9 сая, худалдан авсан бараа материалын буцаалтын 396.5 сая, бараа материалыг акталсан 1,985.0 сая төгрөг зэрэг нийт 54,477.0 сая төгрөгийн бараа материалын зарлага бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Шатахууны анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 5.1 сая төгрөгийн ажил, гүйлгээг бүртгэсэн /Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар 1.7 сая, Говьсүмбэр аймгийн Цагдаагийн газар 1.8 сая, Дорнод аймгийн Цагдаагийн газар 1.6 сая/

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 2,714.4 сая төгрөг болж, өмнөх оноос 477.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	3,192,204.0	2,714,399.2	(477,804.9)
Дүн	3,192,204.0	2,714,399.2	(477,804.9)

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 4 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлээр хуримтлуулан бүртгэсэн 2,714.4 сая төгрөгийн дуусаагүй ажил бүртгэлтэй байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 231,858.8 сая төгрөг болж өмнөх оноос 5,579.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	208,849,664.2	213,734,776.3	4,885,112.1
Барилга, байгууламж, орон сууц	140,475,695.6	145,995,150.6	5,519,454.9
Авто-тээврийн хэрэгсэл	19,820,846.4	21,129,991.0	1,309,144.6
Машин, тоног төхөөрөмж (компьютер)	31,170,266.5	28,792,865.0	(2,377,401.5)
Тавилга, аж ахуйн эд хогшил	5,213,714.5	4,979,566.9	(234,147.7)
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4,537,171.9	4,646,565.8	109,393.9
Бусад үндсэн хөрөнгө	7,631,969.2	8,136,887.8	504,918.7
Дуусаагүй барилга, байгууламж		53,749.3	53,749.3
Биет бус хөрөнгө	17,429,646.2	18,124,020.1	694,374.0
Программ хангамж	933,840.0	891,742.1	(42,097.9)
Бусад биет бус хөрөнгө	16,495,806.2	17,232,278.1	736,471.9
Дүн	226,279,310.4	231,858,796.5	5,579,486.1

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 5,565.6 сая, хандив тусламжаар 203.3 сая, дээд шатны болон бусад байгууллагаас балансаас баланст шилжүүлэн авсан 20,236.2 сая, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 5,976.0 сая, бараа материалаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн 54.5 сая, газар эзэмших эрхийг бүртгэсэн 934.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр акталсан 3,235.3 сая, харьяа байгууллага хооронд балансаас баланст шилжүүлсэн 4,621.7 сая, орон нутгийн өмчийн шийдвэрээр хувьчилсан 57.3 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 543.0 сая, үнэ шинэчлэн тогтоохоор данснаас зарлагдсан 6,284.9 сая, данс хооронд шилжүүлэн бүртгэсэн 85.3 сая, газар эзэмших эрх шилжүүлсэн 32.2 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 6,181.5 сая төгрөг болж, өмнөх оноос 4,987.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг	4,340.6	66,637.5	62,296.9
Байгууллагад төлөх өглөг	2,205,073.1	4,341,955.3	2,136,882.2
Хувь хүмүүст төлөх өглөг	-	253.4	253.4
Татварын өглөг /ТӨҮГ/	63,561.8	51,618.7	(11,943.1)
Дансны өглөг /ТӨҮГ/	28,264.8	5,385.6	(22,879.2)
Урьдчилж орсон орлого	8,867,917.3	1,715,685.7	(7,152,231.5)
Дүн	11,169,157.5	6,181,536.1	(4,987,621.4)

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажиллагсадтай холбоотой өглөгийн 66.6 сая төгрөгийн үлдэгдэлд ХХОАТ-ын 6.5 сая, НДШ-ийн 0.1 сая, цалингийн 60.0 сая төгрөгийн өглөг;

Байгууллагад төлөх өглөгийн дансанд урсгал зардлын 14.2 сая, бусад 59.0 сая, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын автомашины парк шинэчлэлтэй холбоотой үүссэн 4,268.8 сая төгрөгийн өглөг;

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлд 1,521.4 сая төгрөгийн барьцаа дэнчингийн орлого, гэрээт алба хаагчдын хувцасны төлбөр, сургалтын орлого, бууны гэрчилгээний орлого зэрэг 194.3 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр;

Мөн хувь хүмүүст төлөх өглөгийн 0.3 сая, Монгол Тамга ТӨҮГ-ын 51.6 сая төгрөгийн татварын, 5.4 сая төгрөгийн дансны өглөг тус тус бүртгэлтэй байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 296,461.7 сая төгрөг болж, өмнөх оноос 18,642.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	83,315,093.6	84,065,917.3	750,823.7
Хуримтлагдсан үр дүн	137,615,398.9	155,901,589.7	18,286,190.7
Өмнөх үеийн үр дүн	110,373,538.1	138,139,780.2	27,766,242.0
Тайлант үеийн үр дүн	27,241,860.8	17,761,809.5	(9,480,051.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,888,628.4	56,494,197.4	(394,431.0)
Дүн	277,819,120.9	296,461,704.3	18,642,583.4

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл 750.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь харьяа байгууллагууд газар эзэмших эрхийг орлогод авсан нь нөлөөлсөн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 56,494.2 сая төгрөг болж, 394.4 сая төгрөгөөр буурсан нь харьяа газруудын акталсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг хасаж бүртгэсэнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 155,901.6 сая төгрөг болж, 18,286.2 сая төгрөгөөр өссөн нь харьяа 17 байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн залруулга болон тайлант үеийн үр дүн 17,761.8 сая төгрөг байгаа нь нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 688,912.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар төсөв захирагчийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвийн төслийн саналаас 426,973.5 сая төгрөгөөр бууруулж 261,939.3 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: Хөрөнгийн зардлыг 257,040.8 сая, цалин, НДШ-ийн зардлыг 117,051.8 сая, норматив зардлыг 39,137.8 сая, бусад урсгал зардлаас 13,169.3 сая төгрөгөөр тус тус бууруулж хянасан байна. 2021 оны нийт төсөв 261,939.3 сая төгрөгийн 253,540.0 сая төгрөгийг урсгал зардалд, 8,399.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тодотголоор төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт 262,513.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 254,113.8 сая төгрөгийг урсгал зардалд, 8,399.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталсан байна. Нийт зардлын эх үүсвэрийн 251,242.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 252.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 11,017.8 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 242,843.5 сая, хөрөнгийн зардалд 8,236.5 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлж, төлөвлөснөөс 162.8 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр 269.5 сая төгрөгийн санхүүжилт авч, төлөвлөснөөс 17.5 сая төгрөгөөр илүү байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 11,848.2 сая төгрөг бүрдүүлж, төлөвлөснөөс 830.4 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 262,116.3 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь 234.1 сая төгрөг дутуу зарцуулсан, хөрөнгийн санхүүжилт 162.8 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 11 төсөл, арга хэмжээнд 8,236.5 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 7,797.2 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлээр олгож, 439.3 сая төгрөгийг барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	70704	Цагдаа	248,617,331.1	248,405,911.1	211,420.0	100.0
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	212,091,955.6	212,776,157.6	(684,202.0)	100.0
1.2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	15,500,000.0	15,480,251.5	19,748.5	100.0
1.3	80220	Холбооны суваг ашигласны хөлс	89,976.9	89,976.9	0.0	100.0
1.4	80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	74,027.1	73,635.5	391.6	99.0
1.5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	17,461,483.3	17,419,564.1	41,919.2	100.0
1.6	81501	Ерөнхийлөгчийн сонгууль	682,850.0	682,792.2	57.8	100.0
1.7	81822	Гадаад суралцагсдын зардал	799,808.4	799,808.4	0.0	100.0
1.8	82201	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	84,484.2	84,484.0	0.2	100.0
1.9	82315	Байцаан шийтгэх ажиллагаа	882,917.9	49,415.6	833,502.3	6.0
1.10	82324	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа	949,827.7	949,825.4	2.3	100.0
2	70711	Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах	5,496,513.9	5,473,860.2	22,653.7	100.0
2.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,493,513.9	5,470,860.2	22,653.7	100.0
2.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	3,000.0	3,000.0	0.0	100.0
3	72301	Бусад	8,399,300.0	8,236,532.2	162,767.8	98.0
3.1	80918	Хөрөнгө оруулалт их засвар	8,399,300.0	8,236,532.2	162,767.8	98.0
		Нийт дүн	262,513,145.0	262,116,303.5	396,841.5	99.8

Зарцуулаагүй үлдэгдэл болон үндсэн үйл ажиллагааны давсан орлого 1,081.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

- Урсгал зардлаас 23.6 сая төгрөгийн хөрөнгийн худалдан авалт хийсэн. /Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар 7.4 сая, Ховд аймаг дахь Цагдаагийн газар 10.0 сая, Налайх дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс 3.7 сая, Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс 2.5 сая/;
- Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс нь 5.7 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан;
- Налайх дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс нь 2.1 сая төгрөгийн ээлжийн амралтын цалинг давхардуулан олгосон;
- Засгийн газраас тогтоосон босго үнийн дүнгээс давсан бараа, ажил, үйлчилгээний 109.5 сая төгрөгийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн /Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс 60.2 сая, Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс 49.3 сая/

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 142.5 сая, аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 794.6 сая, дээд шатны төсвийн захирагчаас 2,092.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 12,543.8 сая, нийт 15,573.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 14,457.8 сая, хөрөнгийн зардалд 604.8 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 510.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 5 үзүүлэлтийн зорилтот түвшинд 83 арга хэмжээ баталснаас, гүйцэтгэлээр 98.1 хувийн биелэлттэй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 13 арга хэмжээний хүрээнд хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 9 үзүүлэлтийн зорилтот түвшинд 262,513.1 сая төгрөг баталснаас, гүйцэтгэлээр 99.8 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 10. Цагдаагийн ерөнхий газрын 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД		2021 хүрэх түвшин	2021 онд хүрсэн түвшин	Хувь
Цагдаа				
21.2.1	Хэргийг хэрэг бүртгэлт явуулж эхэлснээс хойш хуулийн хугацаанд шийдвэрлэх хувь	80	82.3	103.0
21.2.2	Эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн илрүүлэлт /хувиар/	50	77.5	155.0
21.2.3	Хэрэг илрүүлэлт /хувиар/	50	52.7	105.0
21.2.4	Гэмт хэрэг, захиргааны зөрчил, гал түймэр, гамшиг, осол, эмнэлгийн яаралтай тусламжийг хангасан бодит мэдээллийн хувь	90	100	111.0
21.2.5	Гэрч, хохирогчийн хамгаалалт /хүнээр/	70	234	334.0
21.2.6	Шүүхийн байрын хамгаалалт /хувиар/	100	100	100.0
21.2.7	Шүүх хурлын танхимын хамгаалалт /хувиар/	100	100	100.0
21.2.8	Шүүгчийн хамгаалалт /хувиар/	100	100	100.0
21.2.9	Шүүгчийн захирамжаар албадан авчрах /хувиар/	85	91.1	107.0

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг гүйцэтгэлтэй харьцуулахад давж биелсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн “Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай” 126 дугаар тогтоолоор Цагдаагийн ерөнхий газрын Цагаан шонхор төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын удирдлага, эд хөрөнгийн талаарх бүрэн эрхийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хууль тогтоомжийн хүрээнд шилжүүлэхийг ТӨБЗГ-т даалгаж, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг баталж, мөрдүүлэхийг ХЗДХС-д зөвшөөрсөн байна.

3.8 Аудитын гол асуудал

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 117-д тусгасан Цагдаагийн байгууллагын автопарк шинэчлэлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга

хэмжээг санхүүгийн түрээсийн гэрээгээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, тайлант онд нийт төлбөрийн 21.0 хувийг төлсөн байна.

3.9 Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд нийт 7897 мэдээлэл байршуулахаас 7715 мэдээллийг хугацаанд нь 182 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасантай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөмж өгөв.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 2,530.4 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 2,148.7 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 381.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 550.6 сая төгрөгийн зөрчил арилгах 3 албан шаардлага, 854.1 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилтийн байдал дараах байдалтай байна.

Хүснэгт.11 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	550,600.0	1.5	-	1.5	550,600.0	50.0
Зөвлөмж	4	854,100.0	4	854,100.0	-	-	100.0
Нийт дүн	7	1,404,700.0	5.5	854,100.0	1.5	550,600.0	75.0

Өмнөх оны аудитаар өгсөн урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад анхаарал татахуйц, дараагийн аудитаар дахин авч үзэх асуудлууд байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 9 дүгээр тогтоолоор Цагдаагийн ерөнхий газрын харьяа Монгол тамга ТӨҮГ-ыг татан буулгах шийдвэр гаргасан боловч санхүүгийн тайлан дахь авлага, өр төлбөрийг барагдуулаагүйгээс төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн

нэгтгэсэн тайланд үлдэгдлээр нэгтгэгдсээр байгаа тул 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянах;

- Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа болон он дамжин хэрэгжиж байгаа 3 төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,512.2 сая төгрөгийн 115 алдаа, зөрчил илэрснээс, 7,660.5 сая төгрөгийн 45 алдааг залруулж, 4.1 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 364.9 сая төгрөгийн 11 албан шаардлага хүргүүлж, 1,482.7 сая төгрөгийн зөрчилд 56 зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 1,851.7 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 2,515.5 сая төгрөгөөс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 54 төсвийн байгууллага, 1 төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан нийт 55 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 37 байгууллагад дүгнэлт гаргаж, 18 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан 37 харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 7,967.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 7,324.1 сая төгрөгийн 31 алдааг аудитын явцад залруулж, 4.1 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 243.2 сая төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 395.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 55 зөвлөмжийг хүргүүллээ.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Цагдаагийн ерөнхий газрын харьяа 14 байгууллага ахмадын санд төвлөрүүлсэн 336.3 сая төгрөгийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд бараа, үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх” Ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.2 Албан шаардлага

1. Хуульд заасны дагуу төсөл, арга хэмжээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж худалдан авах ажиллагааны журмыг сонголгүйгээр 108.7 сая төгрөгийн “Сүлд” чуулгын алба хаагчдын уран бүтээлийн тоглолтын хувцас худалдан авах ажлын төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, 8.7.1-т “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох” заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

2. Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь цагдаагийн газар нь харуул хамгаалалтын бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 121.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зарцуулахдаа төсвийн эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд шилжүүлэхгүй байх, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

4.2.3.Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1 Илрүүлэлт:

ЦЕГ-ын даргын 2021 оны урсгал зардлаас 817.1 сая төгрөгийн компьютер, 270.0 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл зэрэг нийт 1,087.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийн урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх.

2.1 Илрүүлэлт:

Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,858.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 7,324.1 сая төгрөгийн алдааг залруулж, 4.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 134.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 395.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-т “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулж, аудитаар илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар нэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлтийн төрөл						Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс:							
		Бүгд	Үүнээс							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	Түүвэрт хамруулсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
Архангай аймаг дахь Цагдаагийн газар	АРА-2022/27/НА-СТА-ТШЗ	1	1					-	-	-	-						
Булган аймаг дахь Цагдаагийн газар	БУА-2022/108/НА-СТА-ТШЗ	1	1					2	884.2							2	884.2
Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар	БӨА-2022/164/НА-СТА-ТШЗ	1	1					-	-								
Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар	БНА-2022/99/НА-СТА-ТШЗ	1	1					2	76,000.0	2	76,000.0					-	-
Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн хэлтэс	ГАА-2022/70/НА-СТА-ТШЗ	1	1					5	33,025.6	3	31,100.0	1	1,685.4	1	240.2		
Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс	ГСА-2022/24/НА-СТА-ТШЗ	1	1					4	7,987.2	1	5,100.0	1	320.4	2	2,566.8		
Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газар	ДАА-2022/128/НА-СТА-ТШЗ	1	1					3	1,963,962.0	3	1,963,962.0						
Дорноговь аймаг дахь Цагдаагийн газар	ДГА-2022/115/НА-СТА-ТШЗ	1	1					4	34,800.0	2	30,100.0					2	4,700.0
Дорнод аймаг дахь Цагдаагийн газар	ДОА-2022/177/НА-СТА-ТШЗ	1	1					1	1,600.0							1	1,600.0
Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс	ДГА-2022/116/НА-СТА-ТШЗ	1	1					2	2,500.0	2	2,500.0						
Дундговь аймаг дахь Цагдаагийн хэлтэс	ДУА-2022/16/НА-СТА-ТШЗ	1	1					1	18,183.1	1	18,183.1						
Завхан аймаг дахь Цагдаагийн газар	ЗАА-2022/196/НА-СТА-ТШЗ	1	1					-	-								
Орхон аймаг дахь Цагдаагийн газар	ОРА-2022/15/НА-СТА-ТШЗ	1	1					5	88,808.6	1	77,454.3					4	11,354.3

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс	СЭА-2022/239/НА-СТА-ТШЗ	1	1				4	18,846.4							4	18,846.4
Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэсэг	СЭА-2022/239/НА-СТА-ТШЗ	1	1				4	22,605.7							4	22,605.7
Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газар	СЭА-2022/238/НА-СТА-ТШЗ	1	1				3	16,543.6							3	16,543.6
Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн хэлтэс	СБА-2022/08/НА-СТА-ТШЗ	1	1				-	-								
Төв аймаг дахь Цагдаагийн газар	ТӨА-2022/21/НА-СТА-ТШЗ	1	1				2	5,500.0	1	3,300.0					1	2,200.0
Увс аймаг дахь Цагдаагийн газар	УВА-2022/42/НА-СТА-ТШЗ	1	1				-	-								
Ховд аймаг дахь Цагдаагийн газар	ХОА-2022/27/НА-СТА-ТШЗ	1	1				3	19,720.0							3	19,720.0
Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар	ХЭА-2022/06/НА-СТА-ТШЗ	1	1				1	7,200.0					1	7,200.0		
Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар	ХӨА-2022/253/НА-СТА-ТШЗ	1	1				2	22,600.0							2	22,600.0
Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс	ӨВА-2022/1/НА-СТА-ТШЗ	1	1				-	-								
Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар	ӨВА-2022/113/НА-СТА-ТШЗ	1	1				-	-								
Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар	ӨМА-2022/118/НА-СТА-ТШЗ	1	1				3	8,613.7	1	0.2					2	8,613.5
Нийслэлийн цагдаагийн удирдах газар	НТАГ-2022/38/НА-СТА-ТШЗ	1	1				3	107,670.5					1	81,968.4	2	25,702.1
Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс	НТАГ-2022/98/НА-СТА-ТШЗ	1	1				7	247,731.8	2	236,371.7			1	4,956.1	4	6,404.0
Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс	НТАГ-2022/185/НА-СТА-ТШЗ	1	1				2	7,738.1							2	7,738.1
Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газар	НТАГ-2022/78/НА-СТА-ТШЗ	1	1				3	666,647.7	2	658,888.7					1	7,759.0
Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар	НТАГ-2022/95/НА-СТА-ТШЗ	1	1				5	145,291.1	2	111,834.9			1	6,975.5	2	26,480.7
Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газар	НТАГ-2022/94/НА-СТА-ТШЗ	1	1				4	38,748.1					1	25,699.9	3	13,048.2

СХД дүүрэг дэх Цагдаагийн газар	НТАГ-2022/70/НА-СТА-ТШЗ	1	1				6	3,959,530.4	3	3,865,824.6					3	93,705.8
Чингэлтэй дүүрэг Цагдаагийн газар	НТАГ-2022/91/НА-СТА-ТШЗ	1	1				2	10,216.0	1	700.0					1	9,516.0
Хан-Уул дүүрэг Цагдаагийн газар	НТАГ-2022/54/НА-СТА-ТШЗ	1	1				6	283,978.3	1	217,747.0					5	66,231.3
Налайх дүүрэг Цагдаагийн хэлтэс	НТАГ-2022/99/НА-СТА-ТШЗ	1	1				5	22,725.4	1	11,154.5	1	2,100.6			3	9,470.3
Санхүү, аж ахуйн алба	АХГ-2022/327/НА-СТА-ТШЗ	1				1	3	1,392,899.5	1	197,197.3			1	108,696.0	1	1,087,006.2
Захиргааны удирдлагын газар	АХГ-2022/318/НА-СТА-ТШЗ	1				1	1	6,283.0	1	6,283.0						
Хангалт үйлчилгээний төв	АХГ-2022/15/НА-СТА-ТШЗ	1	1				4	18,823.7	2	13,898.8			1	4,924.9	1	-
Авто бааз	АХГ-2022/320/НА-СТА-ТШЗ	1				1	1	7,300.9	1	7,300.9						
ЦЕГ-МДШУА	АХГ-2022/340/НА-СТА-ТШЗ	1				1	1	2,485.2	1	2,485.2						
Сүүж-Уул нөхөн сэргээх сувилал	АХГ-2022/314/НА-СТА-ТШЗ	1				1	-	-								
Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах алба	АХГ-2022/15/НА-СТА-ТШЗ	1				1	1	44,816.7	1	44,816.7						
Дотоодын цэргийн 05 дугаар анги	АХГ-2022/323/НА-СТА-ТШЗ	1				1	1	29,666.7	1	29,666.7						
Дотоодын цэргийн 805 дугаар анги	АХГ-2022/325/НА-СТА-ТШЗ	1				1	-	-								
Төмөр зам дахь цагдаагийн газар	АХГ-2022/321/НА-СТА-ТШЗ	1				1	2	125,334.4	1	3,670.2			1	121,664.2		
Цагдаа, дотоодын цэргийн сургалт нэгдсэн дадлагын төв	АХГ-2022/310/НА-СТА-ТШЗ	1				1	1	520.3	1	520.3						
Сүлд чуулга	АХГ-2022/315/НА-СТА-ТШЗ	1				1	1	1,375.4	1	1,375.4						
Хүч спорт хороо	АХГ-2022/324/НА-СТА-ТШЗ	1				1	1	3,200.8	1	3,200.8						
Техник засварын төв	АХГ-2022/15/НА-СТА-ТШЗ	1	1				-	-								
Эрүүгийн цагдаагийн алба	АХГ-2022/311/НА-СТА-ТШЗ	1				1	1	246.0	1	246.0						
Мөрдөн байцаах алба	АХГ-2022/322/НА-СТА-ТШЗ	1				1	1	9,053.0	1	9,053.0						
Тээврийн цагдаагийн алба	АХГ-2022/313/НА-СТА-ТШЗ	1				1	1	21,019.0	1	21,019.0						
Экологийн цагдаагийн алба	АХГ-2022/317/НА-СТА-ТШЗ	1				1	1	9,498.0	1	9,498.0						

Цагдаагийн гэрээт хамгаалалт	АХГ-2022/316/НА-СТА-ТШЗ	1					1	-	-								
Монгол тамга ТӨҮГ		1					1	-	-								
Дүн		55	37	-	-	-	18	115	9,512,180.1	45	7,660,452.3	3	4,106.4	11	364,892.00	56	1,482,729.4

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/										
д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс:					
					Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	Б	В	1	2	3	4	5	6	7	8
1	Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар	БӨА-2022/164/НА-СТА-ТШЗ	1	-					1	-
2	Булган аймаг дахь Цагдаагийн газар	БУА-2022/108/НА-СТА-ТШЗ	1	-					1	-
3	Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс	ГСА-2022/24/НА-СТА-ТШЗ	1	45,426.6	1	45,426.6				
4	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс	СЭА-2022/239/НА-СТА-ТШЗ	1	-					1	-
5	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэсэг	СЭА-2022/239/НА-СТА-ТШЗ	1	-					1	-
6	Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар	ХӨА-2022/253/НА-СТА-ТШЗ	1	-					1	-
7	Хангалт үйлчилгээний төв	АХГ-2022/15/НА-СТА-ТШЗ	1	-					1	-
8	Нийслэлийн цагдаагийн удирдах газар	НТАГ-2022/38/НА-СТА-ТШЗ	1	2,103,263.4	1	2,103,263.4				
9	Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газар	НТАГ-2022/78/НА-СТА-ТШЗ	1	5,554.3					1	5,554.3
10	Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар	НТАГ-2022/95/НА-СТА-ТШЗ	1	92,773.6					1	92,773.6
10	Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газар	НТАГ-2022/91/НА-СТА-ТШЗ	1	64,448.9					1	64,448.9
11	Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газар	НТАГ-2022/54/НА-СТА-ТШЗ	1	208,266.0					1	208,266.0
12	Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс	НТАГ-2022/98/НА-СТА-ТШЗ	1	10,631.2					1	10,631.2
	Дүн		13	2,530,364.0	2	2,148,690.0	-	-	11	381,674.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 05

№ 696/АДК00058

Улаанбаатар хот

АХГ - 2022/15/НА - СТА - ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хуульд заасны дагуу төсөл, арга хэмжээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж, худалдан авах ажиллагааны журмыг сонголгүйгээр 108,696,000.00 *Инэг зуун найман сая зургаан зуун ерэн зургаан мянган төгрөгийн "Сүлд" чуулгын алба хаагчдын уран бүтээлийн тоглолтын хувцас худалдан авах ажлын төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.*

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 8.7.1 "тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны журмын дагуу худалдан авалтыг зохион байгуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ЦЕГ-ын дарга, хошууч генерал Ж.Болд, Ерөнхий нягтлан бодогч, Санхүү, аж ахуйн албаны Санхүүгийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа Н.Алтансүх нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ХОСЖАРГАЛ

С.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Iban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-343.Docx

0001081743



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 697/А0150055

Улаанбаатар хот

АХТ-2022/15/НА-СТА-Т13

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь Цагдаагийн газар нь харуул хамгаалалтын бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 121,664,200.00 /нэг зуун хорин нэгэн сая зургаан зуун жаран дөрвөн мянга хоёр зуу/ төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг зарцуулахдаа төсвийн эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд шилжүүлэхгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ЦЕГ-ын Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь Цагдаагийн газрын дарга, хурандаа А.Батбаяр, Ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч И.Цэрэнпэлжид нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

